

АУДИТЫН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

1. **Увс аймаг дахь Төрийн аудитын газар нь ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГА, ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ЭТГЭЭДИЙН 2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ГЭРЭЭГЭЭР АУДИТ ХИЙХ ХАРААТ БУС АУДИТЫН КОМПАНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ** тул аудитын үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг сонирхолоо илэрхийлэхийг урьж байна.

2. Энэхүү аудитын үйлчилгээ нь Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу Санхүүгийн тайланд аудит хийх чиг үүргээ аудитын бусад байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэхээр зарлаж байна. Аудитын үйлчилгээний гэрээний нийт хугацаа нь 2019 оны 01 дүгээр сарын 02-оос 2019 оны 03 дугаар сарын 30-ны хооронд гүйцэтгэнэ.

3. Мэдүүлгээ ирүүлж буй аудитын хуулийн этгээд нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараах мэдээлэл болон холбогдох бичиг баримтын баталгаат хуулбарыг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

1. Улсын бүртгэлийн гэрчилгээ, аудит хийх тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа нь тухайн жилд аудит хийх хуулийн цаглабар хугацаатай нийцсэн эсэх;
2. Аудитын компани нь хариуцлагын даатгалтай эсэх;
3. Аудитын компанийн захирал нь мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрхтэй эсэх;
4. Аудитын компани нь 4-өөс доошгүй мэргэшсэн нягтлан бодогчтой эсэх;
5. Аудитын компанийн захирал болон мэргэшсэн нягтлан бодогчид нь мэргэжлийн ёс зүйн алдаа гаргаагүй талаар Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт (ММНБИ)-ийн тодорхойлолттой эсэх;
6. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийн 21.1 дэх заалтыг зөрчөөгүй байх;
7. Төрийн аудитын байгууллагын захиалгаар сүүлийн 3 жилийн хугацаанд аудитын ажил гүйцэтгэж байсан туршлагатай байх, хэрэв ийм ажил гүйцэтгээгүй бол мөн хугацаанд улсын салбарт ижил төстэй ажил хийсэн туршлагатай байх.
8. Сангийн Яам болон бусад мэргэжлийн байгууллагаас хийгдсэн чанарын баталгаажуулалтын дүгнэлт.

Эдгээр нь Хураангуй жагсаалт бэлтгэх үндэслэл болно. Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор аудитын хуулийн этгээдүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.

Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг утсаар авч болох бөгөөд мэдүүлгээ дор дурдсан хаягаар 2018 оны 12 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Увс аймаг дахь Төрийн аудитын газар
Утас: 70453317, 70453721